



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**ШУДАРГА ӨРСӨЛДӨӨН,
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗАР**

Засгийн газрын XII байр, Барилгачдын талбай 13,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: 26 26 53, Факс: (976-11) 32 00 41,
Цахим шуудан: contact@afccp.gov.mn,
Цахим хуудас: www.afccp.gov.mn

2024 · 07 · 23 № 03 / 1356
танай _____ -ны № _____ -т

Г Тендерийн баримт бичиг
хянасан тухай Г

Танай албанаас зарласан “Угсармал орон сууцны барилгыг дулаалах ажил (Баянзүрх дүүрэг, 41 дүгээр хороо, 1 дүгээр байр)” НХААГ/202310369 дугаартай тендер шалгаруулалтын баримт бичигт “Термобазальт” ХХК-аас гомдол ирүүлснийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлд заасны дагуу хяналаа.

1. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.2-т “Ажил гүйцэтгэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: Шаардана. Машин механизмын тоног төхөөрөмжийн нэр: Автокран-1, Ачааны машин-1, гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн машин механизмын 50-аас илүү хувь нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байна” гэж заасан байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.” гэж заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.2-т заасан шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа 2 машин механизмын шаардсан боловч зайлшгүй шаардлагатай үндсэн машин механизмын 50-аас илүү хувь нь тендерт оролцогчийн өөрийн эзэмшлийнх байна гэж заасан нь тендерт оролцогчдод ойлгомжгүй байдал үүсгэж байх тул Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасныг зөрчсөн байна.

2. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.4-т “Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: Шаардана. а) Тендерт санал болгосон инженер техникийн ажилтнуудын 30-аас дээш хувь нь одоо хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан дуусаагүй ажилд давхацсан тохиолдолд тухайн тендерээс татгалзана. Одоо хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд ажиллаж буй инженер техникийн ажилчдын мэдээллийг захиалагчаар баталгаажуулж ирүүлнэ” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.4-т заасан шалгуур үзүүлэлтийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНД

0003025

тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6-д “Захиалагч оролцогчийн хэрэгжүүлж байгаа гэрээний хэрэгжилтийн талаарх мэдээлэл ирүүлэхийг тендер шалгаруулалтын баримт бичигт зааж болно” гэж заасны дагуу боловсруулсан байна.

Гэвч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.1.4-т “тендерт санал болгосон инженер техникийн ажилтнуудын 30-аас дээш хувь нь одоо хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан дуусаагүй ажилд давхацсан тохиолдолд тухайн тендерээс татгалзана. Одоо хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээнд ажиллаж буй инженер техникийн ажилчдын мэдээллийг захиалагчаар баталгаажуулж ирүүлнэ” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Захиалагч гэрээний үүрэг гүйцэтгэхэд сонирхогч этгээд болон оролцогчид тавигдах зайлшгүй шаардлагад үндэслэсэн...доод шаардлага, шалгуур үзүүлэлтийг тендер шалгаруулалтын баримт бичигт заана” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

3. “Угсармал орон сууцны барилгыг дулаалах ажил (Баянзүрх дүүрэг, 41 дүгээр хороо, 1 дүгээр байр)” НХААГ/202310369 дугаартай тендер шалгаруулалтыг 2024 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зарласан байх бөгөөд тендерийн баримт бичгийн ТШЗ 19.2.1.в) Тендерт оролцогчийн үндсэн ажилтан нь сүүлийн 3 сар (2024 оны 03, 04, 05 дугаар сар) тухайн компанидаа ажилласан байх шаардлагатай бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана” гэж заасан нь зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

4. Тендерийн баримт бичгийн ТШЗ 19.2.3-т “Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ. Үүнд: в) Захиалагчийн тодорхойлолт: Ижил төстэй ажилд Барилгын засвар, дулаалгын ажил хийж гүйцэтгэсэн туршлагыг тооцно. Захиалагчийн тодорхойлолт нь тухайн ажилд зориулж авсан байна” гэж тус тус заасан байна.

Захиалагч тендерийн баримт бичгийн ТШЗ 19.2.3-т “...Захиалагчийн тодорхойлолт нь тухайн ажилд зориулж авсан байна” гэж заасан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд өрсөлдөх тэгш боломжтой, ил тод...байх зарчмыг баримтална.” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.5.2 дахь заалтыг үндэслэн тендер шалгаруулалтын баримт бичгийн ТШЗ 19.1.2, ТШЗ 19.1.4, ТШЗ 19.2.3-т тус тус холбогдох өөрчлөлт оруулан хэрхэн шийдвэрлэсэн талаар хариу мэдэгдсэний үндсэн дээр тендер шалгаруулалтыг үргэлжлүүлэн явуулахыг даалгаж байна.

ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Э.ЭРДЭНЭЦЭГ